

ЭКЗИСТЕНЦИАЛИЗМ МОНГОЛЫН УРЛАГ, УРАН ЗОХИОЛД НӨЛӨӨЛСӨН НЬ

Б.Дэлгэрмаа - МУИС-ийн урлаг судлалын тэнхимийн багш, философийн ухааны доктор (Ph.D)

Түлхүүр үг: Экзистенци, оршихуй, амьдралын утга учир, эрх чөлөө, үүрэг хариуцлага, сонголт, ганцаардал, абсурд

Энэ өгүүлэлдээ экзистенциализмын философийн гол гол ойлголтуудыг эхлээд тайлбарлаад, дараа нь Монголын урлаг, уран зохиолд экзистенциализм хэрхэн нөлөөлсөн тухай асуудлыг гаргаж бичихийг зорилоо.

Орчин үеийн философийн олон чиглэлийн нэг нь экзистенциализм юм. Экзистенциализмын философи нь хүний оршихуйн асуудал, хүний амьдралын утга учрын асуудлыг голчлон авч үздэг. XIX зуунаас өмнөх философиуд оюун санаа, сэтгэхүйг чухалчилдаг байсан. Тэдгээр нь шинжлэх ухаанаар ертөнцийг танин мэднэ гэж үздэг. Харин XX, XXI зууны философи нь хүн рүүгээ хандаж, хүний дотоод сэтгэлийн асуудлыг илүүтэй авч үзэх болсон юм. Экзистенциализм бол философи ч мөн, урлаг уран зохиолын чиглэл ч мөн. Орчин үед урлаг, философи хоёр нэгдмэл байдалтайгаар хөгжих боллоо.

Экзистенциализмд яригддаг гол ойлголт нь экзистенци, эрх чөлөө, үүрэг хариуцлага, сонголт, ганцаардал, абсурд зэрэг юм. Францын философич Жан Поль Сартр (1905-1980), Альбер Камю (1913-1960) нар экзистенциализмын философид хамгийн нэр нөлөө бүхий төлөөлөгчид билээ. Тэд хүний амьдралын утга учир, оршихуйн асуудлыг боловсруулж байсан. Ж.П.Сартр амьдралын утга учрын асуудлыг хувь хүний эрх чөлөө, хариуцлага, сонголтын асуудалтай холбон сонирхолтой байдлаар гаргаж ирсэн байдаг. А.Камю хүний амьдралын утга учрын тухай, оршихуйн тухай асуудлыг боловсруулахдаа “абсурд” хэмээх категорийг өөрийн философийн гол уг сурвалж болгож үзэж байсан. Урлаг нь оюун дүгнэлт алга болж, түүний оронд утга учиргүй (абсурд) хүсэл зорилго гарч ирсэн тохиолдолд гарч ирдэг, урлагийн бүтээл нь оюун ухаан тодорхойг тайлбарлахаас зайлсхийсэн үед бий болдог гэсэн урлагийн философийн чухал дүгнэлтийг тэр гаргасан юм. Экзистенциализм нь урлагийн тухай тайлбарлахдаа оюун ухааны пессимизм ба хүсэл зоригийн оптимизмын үүднээс тодорхойлдог¹. Сартр, Камю нар шашингүйн үзэлтнүүд бөгөөд хүний амьдрал хувь заяаг Бурхан аврахгүй, хүнийг өөрөөс нь өөр хэн ч аврахгүй гэж үзэж байсан. Энэ талаар Сартр “Экзистенциализм бол хүмүүнлэг үзэл мөн” зохиолдоо: “Хүн өөрийгөө олж авах ёстой бөгөөд хүнийг өөрөөс нь өөр юу ч, тэр тусмаа бурханы оршин байгаагийн магадтай нотолгоо ч аврахгүйд үнэмших ёстой. Энэ утгаараа экзистенциализм бол хүмүүнлэг үзэл, үйл ажлын тухай сургаал мөн”² гэж бичжээ. Хүн амьд явах нь чухал, хүн амьдралыг дээд зэргээр амьдарч туулах ёстой гэдэг үзлийг тэд боловсруулж гаргаж байсан. Ийнхүү тэд экзистенциализм бол хүмүүнлэг үзэл мөн гэдгийг

¹ О.А.Кривцун. Эстетика. М., 1998., с. 403

² Ж.П.Сартр. Экзистенциализм бол хүмүүнлэг үзэл мөн. УБ., 2007 он, 27-р талд

өөрсдийн зохиол бүтээлээрээ илэрхийлсэн байдаг. Зарим судлаачид экзистенциализмыг пессимист үзэл гэж үздэг. Харин бид үүнтэй санал нийлэхгүй байгаа бөгөөд экзистенциализм бол хүнийг амьд явахыг чухалчилдагаараа хүмүүнлэг үзэл юм. Амьдралын аливаа асуудалд хүн өөрөө сонголтыг хийнэ гэж экзистенциалистууд үздэг. Мөн хүн эрх чөлөөтэй байх ёстой гэж экзистенциализмд үздэг юм. “Эрх чөлөөтэй байна гэдэг нь хүн өөрөө өөрөөрөө байх”¹ гэсэн үг ажээ.

Одоо экзистенциализм Монголын урлаг, уран зохиолд хэрхэн нөлөөлж бэйгаа талаархи асуудлыг авч үзье.

Монгол оронд 1990 онд ялсан Ардчилсан хувьсгалын үр дүнд Монголын урлаг, уран зохиол зөвхөн “социалист реализм” хэмээх урлан бүтээх арга барилаасаа татгалзаж, уран бүтээлчид чөлөөт сэтгэлгээгээр бүтээлээ туурвих болсон билээ. Монголд 1990-ээд оноос хойш гарсан олон уран бүтээлүүдээс Б.Галсансүх, С.Анударь, Д.Урианхай, Б.Баттулга, Н.Амаржаргал зэрэг зохиолч, яруу найрагчдын зарим зохиолыг экзистенциалист чиглэлд хамааруулж үзэж болохоор байна.

Б.Галсансүхийн 1994 онд бичсэн “Миний Элигия” шүлэг бол экзистенциалист уран бүтээл юм гэж үзэж байна. Яруу найрагч уг шүлгээ “Дахиад зүүд-2” хэмээх давхар гарчгийн доор бичсэн байдаг. Шүлгийн зарим хэсгээс толилуулвал:

“Нэг, хоёр, гурав, дөрөв, тав, зургаа, долоо

Надад үхэх долоон шалтгаан хэрэгтэй...

...Би байна

Би байхгүй...”² гэх зэргээр бичжээ.

Экзистенциализмд амьдрах уу, болих уу гэдгээ шийдэх нь хүний хувьд чухал асуудал байдаг. Энэ философид яригддаг амьдралаа үргэлжлүүлэх эсэхээ хүн хэрхэн шийдэх нь түүний сонголтын эрх чөлөө юм. Чухам энэ асуудлыг Б.Галсансүх өөрийн шүлэгтээ гаргажээ. Мөн энд Галсансүхийн “Ганцаардал” шүлгийг авч үзье. Энэ шүлэгт ганцаардлыг эрх чөлөө мөн гэж үзсэн байна. Үүнд:

“...Ганцын аугаа орчлонгоо алдахаас би айнам

Ганцаардал минь намайг амраг бүсгүй мэт тэврээч...

...Туулайн сүг зурагны эвэр мэт саран дор

Түгшиж л явна даа

¹ В.А.Канке. Философи. УБ., 2009 он, 134-р талд

² Б.Галсансүх. Миний Элигия. Монголын уран зохиолын дээжис. 108 боть. УБ., 2008 он, 104-р боть, 99-р талд

Түших нөхрийг минь

Ганцаардал гэдэг..." гэжээ. Хүн эрх чөлөөтэй байхаас гадна содон байхын тулд ганцаарддаг гэсэн санаа уг бүтээлд бий. Ганцаардал нь бусад хүмүүсээс өөр байх эрх чөлөөг олгодог.

Н.Амаржаргалын "Мөн чанар" хэмээх шүлэг нь хүний оршихуй, амьдралын утга учрыг маш товч тодорхой гаргажээ. Шүлгийг бүрэн эхээр нь сийрүүлвэл:

"Нүв нүцгэн орчлонд"

Нүв нүцгэн ирсэн.

Нүв нүцгэн амьдрал дунд

Нүв нүцгэн өссөөн.

Нүв нүцгэн дурлалд

Нүв нүцгэн тэврүүлж,

Нүв нүцгэн үрээ

Нүв нүцгэн төрүүлж,

Нүв нүцгэн уйлж

Нүв нүцгэн дуулж,

Нүв нүцгэн амьдарсаар л..

Нүв нүцгэн буцах нь ээ

Нүв нүцгэн биенээс

Нүв нүцгэн сүнс дайжиж

Нүв нүцгэн хорвоод

Нүв нүцгэн "ижийнхээ" эрэлд одноо"¹ гэжээ.

Зохиолч Амаржаргал экзистенциализмын философид яригддаг хүний оршихуй, амьдралын утга учрын асуудлыг яруу найргийн хэлээр өөрийн шүлэгтээ, төрсөнөөс үхэх хүртэлх хүний амьдрал ямар богинохон байдгийг хэдхэн мөрөөр илэрхийлэн гаргасан байна.

Орчин үеийн философич, зохиолч С.Анударийн (1972-1998) "Ядаж чад, тэгээд" зохиол нь экзистенциалист зохиол юм. Энэ зохиол А.Камюгийн "Этгээд хүн" зохиолтой тун төстэй. "Ядаж чад, тэгээд" зохиолын гол дүр Уртнасан бол Мерсотой их ойролцоо дүр юм. Тэрээр амьдрал бол утга учиргүй гэж үздэг хүн юм. Анударь уг зохиолдоо: "To live is to die"² ("Амьдарна гэдэг бол үхнэ гэсэн үг") гэж бичжээ. Хувь хүний ганцаардал, амьдралын утга учир, сонголт, амьдрах уу болих уу гэдгээ шийдэх нь экзистенциалист философид их чухал асуудал байдаг. Философич Анударь өөрийн зохиолдоо амьдралын утга учрын асуудлыг абсурд хэмээх ойлголтоор илэрхийлж гаргасан байна.

XX зууны театрын түүхэнд "Абсурд жүжиг" хэмээх өөрийн өвөрмөц хэллэг бүхий арга барилыг бий болгосон шинэ төрөл үүсч гарсан билээ. Абсурд жүжиг бол XX зууны 50-60-аад оны Өрнөдийн театрын хөгжилд гарсан дуулиант шинэ үзэгдлүүдийн нэг байсан

¹ Н.Амаржаргал. Мөн чанар. Монголын уран зохиолын дээжис. 108 боть. УБ., 2008 он. 104-р боть, 7-р талд
² С.Анударь. Ядаж чад, тэгээд. Монголын уран зохиолын дээжис. 108 боть. 104-р боть. 18-р талд

юм. “Абсурд” буюу “утга учиргүй” хэмээх философи, урлагийн онолын нэр томьёо нь А.Камю, Ж.П.Сартр, Ф.Ницше нарын экзистенциализмаас эх сурвалжтай юм. Абсурд жүжгийг үндэслэгч нь Ирландын зохиолч Самюэль Беккет, Румыны Эжен Ионеско нар юм. С.Беккет, Э.Ионескогийн жүжгүүдийг Парисын театруудад 1950-иад оны үед тавьсаны дараа “абсурд жүжиг” хэмээх нэр томьёо өргөн хэрэглэгдэх болсон байна. Абсурд жүжгийн зохиолуудыг Монголын уншигчид, үзэгчдийн хүртээл болгох ажлыг манай орчуулагч, уран бүтээлчид хийж эхлээд байна. МУГЖ С.Сарантуяа тэргүүтэй Монголын Драммын Мэргэжлийн жүжигчдийн Төв нь Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн (Соросын Сан), Монголын Зохиолчдын Эвлэлтэй хамтран “Орчин үе-жүжиг, жүжгийн зохиол” сургалт семинарын хүрээнд орчуулагдсан жүжгүүдийг эмхэтгэн ном болгож олны хүртээл болгоод байна. “Абсурд ба абсурд бус жүжгүүд” хэмээх 2002 онд Улаанбаатар хотноо хэвлэгдэн гарсан уг номонд С.Беккетийн “Годоог хүлээх зуур”, Э.Ионескогийн “Хоёр хүний дэмийрэл”, М.Норманы “Тайван нойрсоорой, ээж ээ”, П.Турриний “Ашгүй бүх юм дууслаа” хэмээх Өрнөдийн театруудыг донсолгож байсан алдарт жүжгийн зохиолууд багтжээ. Жүжгүүдийг орчуулагч Ц.Цэнгэл, Д.Батбаяр, Г.Аюурзана нар орчуулсан байна. Абсурд жүжиг бол Өрнөдийн урлагт гарсан декадент урсгалтай ихээхэн холбоотой. Абсурд жүжигт амьдрал, нийгмийн хямрал, доройтлыг этгээд дүр, зохиомжоор илэрхийлж харуулахыг эрмэлздэг юм. Абсурд жүжиг гэдгийг аливаа үзэл суртал, ёс суртахуунаас ангид урлагийг бүтээх гэсэн оролдлого, урлагийг цэвэр урлаг талаас нь хөгжүүлэх гэсэн эрмэлзэл юм гэж бид ойлгох нь зүйтэй болов уу. Энэ бол урлагт байх ёстой нэг урсгал чиглэл юм. Абсурд театрын урлагийг бид урлагийн нэг өвөрмөц төрөл, уран бүтээлчийн бусдаас өөр байх гэсэн эрэл хайгуул, уран сайхны сэтгэлгээний нэг өвөрмөц арга барил юм гэж үзэх хэрэгтэй.

Резюме

В эстетике и философии экзистенциализма современникам импонировало внимание к индивиду, стремление рассмотреть и понять феномен искусства в связи с судьбами человека в современном мире, с теми изменениями, которые претерпевает природа индивидуальности. Роль художественного творчества в реализации свободного самоосуществления, поиске собственного пути, в обретении смысла жизни-все эти проблемы были созвучны ожиданиями времени. Своеобразие экзистенциальной ориентации в толковании возможностей искусства и человека можно определить как пессимизм интеллекта и оптимизм воли.

Ашигласан ном зохиол

1. Абсурд ба абсурд бус жүжгүүд. УБ., 2002
2. С.Анударь. Ядаж чад, тэгээд Монголын уран зохиолын дээжис. 108 боть. УБ., 2008
3. Г.Аюурзана. Орчин цагийн аугаа сэтгэгчид. УБ., 2001
4. Д.Галбаатар, А.Одгэрэл. ХХ зуун-модернизм-сонгодгууд. УБ., 1996
5. А.Камю. Этгээд хүн. УБ., 2009
6. В.А.Канке. Философи. УБ., 2009

7. Ж.П.Сартр. Экзистенциализм бол хүмүүнлэг үзэл мөн. УБ., 2007
8. К.Э.Гильберт, Г.Кун. История эстетики.СПБ., 2000
9. О.А.Кривуун. Эстетика. М., 1998
10. Mel Thompson. Philosophy. New York. 1992
11. Richard Osborn. Philosophy. New York. 1992
12. The concise encyclopedia of Western philosophy and philosophers. New York. 1996